МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 09 өдөр Дугаар А/350 Алтай хот

Жаргалан сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажилд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар 32.7 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 68 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх ЭМЯ/202002120 дугаартай Жаргалан сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлыг "Дэвжих-Очир" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (М.Ууган-Эрдэнэ)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (М.Ууган-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ Ж.ГАНБАТ

C:/My Documents/ZAHNR-3A-4 doc

0201000816